

## ТАНИЛЦУУЛГА

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталж 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна.

Өнөөдрийн байдлаар зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийг 31 байгууллагын 216 нэгжид харьяалагдах 10011 эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлж байгаа бол Улсын ерөнхий прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих бие даасан хэлтэс ажиллаж, улсын хэмжээнд зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаанд тавих хяналтын ажлыг дагнан хариуцсан 68 хяналтын болон ахлах прокурор ажиллаж байна.

Хууль хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжилтүүдийн тайлан мэдээ болон олон нийтийн санал, хүсэлтээс үзэхэд өнгөрсөн хугацаанд хуулийн хэрэгжилттэй холбоотой ахиц дэвшил гарсан.

Тухайлбал, зөрчлийн талаарх прокурорын хяналтын нэгдсэн бүртгэл бий болж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх боломж бүрдсэн, хүн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоох, эрхэнд халдах ажиллагааг байгууллагын дотоод зохион байгуулалтын хүрээнд биш хөндлөнгийн хяналт, зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлдэг болсноор хүний эрхийн зөрчил буурсан, эрх бүхий албан тушаалнуудын мэдлэг, чадвар ахисан зэрэг болно.

Ийнхүү зөрчил шалгах ажиллагааг нэгдсэн стандартаар хэрэгжүүлэх боломж бүрдсэн хэдий ч шат дамжлаг их, хуулийн зарим заалт тодорхойгүй байгаас хэрэглэхэд хүндрэл учирдаг, шүүхийн ялгаатай журмаас шалтгаалан иргэн, хуулийн этгээдийн хүлээх эрх, үүрэг тодорхойгүй зэрэг нийтлэг бэрхшээл тулгарч байна.

Түүнчлэн Монгол Улсад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтны 60-70 хувь нь хуульч бус бусад салбарын мэргэжилтнүүд байгаа тул зөрчил шалгах зарим тодорхой ажиллагаанд мөрдөх журмыг илүү ойлгомжтой болгох шаардлага тулгарч байна. Үүнийг даван туулах, оновчтой зохион байгуулалт шаардлагатай тул хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлэх, улмаар хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах, нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх чиглэлээр сургалтад хамруулах, тодорхой хугацааны зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх юм.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өнгөрсөн 4 жилийн хугацаанд нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч нэгээс бусад тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд бус харин өөр бусад хуулийн шинэчлэлтийг дагалдуулан Зөрчлийн тухай

хуульд тодорхой зөрчлийг хуульчилсантай холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх субъектийн харьяалал тогтооход чиглэсэн байна.

Мөн дээрх асуудлаар болон эрх бүхий албан тушаалтны шалган шийдвэрлэх зөрчлийн харьяаллын давхардал, хийдлийг арилгах, прокурорын хяналтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг сайжруулахад анхаарч, эрх хязгаарлах арга хэмжээ авах үндэслэл, журмыг тодорхой болгох, зөрчлийг газар дээр нь, эсхүл гомдол, мэдээллийг шалгах явцад хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэлийг ялган зохицуулах, холбогдогчийг албдан ирүүлэх үндэслэлийг тодорхой болгох, зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байгаа ялгаатай стандартыг өөрчилж, шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг адил журмаар хэрэгжүүлэх зохицуулалтыг хуульчлах зэрэг тодорхой саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлээд байна.

Иймд дээрх бэрхшээлийг арилгах, Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэл, журам, арга хэрэгслээр хэрэгжүүлэх, тус ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Төслийг боловсруулахад тус хуулийн хэрэгжилтийн практикт гарч байгаа бэрхшээл, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаархи хууль хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжилтнүүдийн болон иргэдийн санал, хүсэлт, бусад орны эрх зүйн зохицуулалтын сайн жишгийг харгалзан үзсэн болно.

Хуулийн төсөлд санал авах ажлыг иргэн, хуулийн этгээд, төрийн болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан зохион байгуулсан бөгөөд иргэдээс нээлттэй санал авахаар хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээллийн цахим хуудсанд байршуулаад байна.

Хуулийн төсөлд дараахь зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтийг тусгасан:

1.хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг Зөрчлийн тухай хуулийн бүтцийн өөрчлөлтөд нийүүлэн бүхэлд нь өөрчлөн найруулж, улмаар экологийн асуудал хариуцсан цагдаагийн алба хаагч байгаль орчинтой холбоотой тодорхой төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх, мөн оюуны өмчийн бүтээлийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой зөрчлийг Гаалийн хяналтын улсын байцаагч давхар харьяалан шийдвэрлэх боломжтой байдлаар нэмэлтийг тусгасан.

2.Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах торгох шийтгэлийг хөнгөрүүлэх нөхцөлийг шалгаж тогтоох, мөн оногдуулсан торгох шийтгэлийн биелэлтийг харгалзан торгуулийг хөнгөрүүлж, гүйцэтгэлийг хангуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргах журмыг шинээр тусгасан.

3.Зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

хуулиар зохицуулж байгаа ялгаатай стандартыг өөрчилж, зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу Эрүүгийн хэргийн шүүх шийдвэрлэхээр өөрчлөн зохицуулсан.

4.Зөрчил шалган тогтоох тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх журмын зохицуулалтыг сайжруулах, давхардал, хийдлийг арилгах зорилгоор холбогдох өөрчлөлтийг тусгасан.

5.Цар тахалын улмаас иргэн, эдийн засгийн тодорхой секторууд үйл ажиллагаа нь алдагдах, зогсох, улмаар санхүүгийн чадавхгүй болж байгаа нь төрийн зүйгээс анхаарал хандуулж, улмаар хэрхэн даван туулах асуудал тулгарсан. Бид уг нөхцөл байдлаас шалтгаалж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд сануулах шийтгэл оногдуулах үндэслэл, журмыг шинээр зохицууллаа. Энэ нь хүн хуулийн этгээдийн хувьд гаргасан зөрчлөө арилгах, дахин зөрчил үйлдэхгүй байх хууль зүйн нэлээд учир холбогдол бүхий шинэлэг хэм хэмжээ тусгагдлаа.

6.Цахим хэлбэрээр зөрчлийг бүртгэх, дугаар олгох, шалгах, шийдвэрлэх талаар шинэлэг зохицуулалт тусгасан. Энэ нь тухайн зөрчлийг орон зайнаас үл хамааран, шуурхай, зөрчил шалгах бүхий л зардлыг хэмнэсэн, цар тахлын нөхцөл байдлаас үл хамааран хууль хэрэгжих нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн шийтгэл оногдуулсан шийдвэр, шийтгэлээс чөлөөлөх шийдвэрийн хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж, оногдуулж байх зэрэг хууль зүйн үндэслэлүүдийг нээлттэй зохицууллаа.

7.Хил хамгаалах байгууллагын хилийн төлөөлөгч, орлогч, туслагч хилийн зурвас, боомтод үйлдэгдсэн тодорхой төрлийн зөрчлийг шалгах хууль зүйн хийгээд практик үндэслэлтэй тул Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийг харьяалуулан шалгуулахаар зохицууллаа. Энэ нь хилийн зурвас, боомтод хууль сахиулах үйл ажиллагаа явуулах, улмаар урьд зохицуулагдаагүй харилцааг зохицуулж, тухайн бүс, газарт үйлдэгдсэн зөрчлийг шалгаж шийдвэрлэх боломжийг бүрдүүллээ.

8.Экологийн цагдаагийн албаны харьяалан шалгах зөрчлийг өргөтгөж, Зөрчлийн тухай хуулийн долоодугаар бүлэгт заасан тодорхой төрлийн зөрчилд хэрэг бүртгэлт явуулах харьяалал тогтоож, шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлж зохицууллаа. Өөрөөр хэлбэл, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг өөрсдөө илрүүлсэн, мэдээллийг хүлээн авсан бол тухайн зөрчлийг шуурхай шалгаж шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Нөгөөтэйгүүр, аливаа зөрчлийн хэргийг тухайн чиглэлээр мэргэшсэн эрх бүхий албан тушаалтанд хууль зүйн хувьд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн. Тухайлбал, Зөрчлийг газар дээр нь, эсхүл гомдол, мэдээллийг шалгах явцад хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэлийг ялган зохицуулж, тавигдах нөхцөлийг тодорхой болгох, зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхдээ бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах заалтыг хуульд тодруулан тусгаж, мөн холбогдогчийг албадан ирүүлэх үндэслэлийг хэт өргөжүүлэн заасныг хязгаарлах, албадан ирүүлэхийг хориглох нөхцөл буюу насанд хүрээгүй холбогдогчийг албадан ирүүлэх эсэхийг тодорхойлох, улмаар прокурорын зөвшөөрлөөр албадан ирүүлэх журмыг зохицуулсан.

Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх хугацаа, шийдвэр гаргах албан тушаалтныг хуульд өөр өөрөөр тогтоож зөрчил үүсгэж байгааг өөрчилж, мөн баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн этгээдэд Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээ авах үндэслэлийг нэмж зохицуулсан.

Түүнчлэн Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа 2022 оны Төсвийн тухай хуулийн төслийг дагалдан боловсруулсан Зөрчил, шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан хилийн мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааг гаалийн байгууллагад нэгтгэн шилжүүлж байгаатай холбогдуулан тус өөрчлөлтийг мөн тусгасан.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан болно.

---oOo---